



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 5000-ТЫН ДЭВСГЭРТ БОЛОН 20, 50, 100, 200 ТӨГРӨГИЙН ЗООСОН МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ 1995 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 33 Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1."Мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт батлах, эрх олгох тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 9-ний 46, 48 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн "5000 төгрөг"-ийн дэвсгэрт болон "20 төгрөг", "50 төгрөг", "100 төгрөг", "200 төгрөг"-ийн зоосон мөнгөн тэмдэгтийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай. 2.Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн "5000 төгрөг"-ийн дэвсгэрт болон "20 төгрөг", "50 төгрөг", "100 төгрөг", "200 төгрөг"-ийн зоосон мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д.Моломжамц)-д зөвшөөрсүгэй. ДАРГА Н.БАГАБАНДИ